

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025.12.15

Д/д	Арга хэмжээ	Хүрэх түвшин	Хугацаа	Биелэлт
1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-нд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, дүгнэлт гаргах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, гомдол мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу шалган хуралдаанаар хуульд заасан хугацааны дотор хэлэлцэн дүгнэлт гаргасан гомдол мэдээллийн тоо байна.	Тухай бүр	Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-нд 2025 онд нийт 9 гомдол, мэдээллийг иргэд, төрийн албан хаагчдаас ирүүлсэн ба үүнээс 3 гомдлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны харьяалан шийдвэрлэх гомдол биш байх тул харьяаллын дагуу буюу Орхон, Дархан-Уул, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороодод шилжүүлсэн. Харин 4 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хороо гомдлыг хүлээн авч, төрийн албан хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг шаардлага, хориглолтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргасан. Дээрх 6 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хорооны гишүүд дарааллын дагуу хариуцсан судалж, дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж Ёс зүйн дэд хорооноос ёс зүйн зөрчилгүй гаргаагүй тухай 4 дүгнэлт, Ёс зүйн зөрчилтэй тухай 2 дүгнэлтийг ус гаргасан. Ёс зүйн зөрчил гаргасан тухай 2 дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. Үүний дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах” ёс зүйн болон сахилгын шийтгэл ногдуулан шийдвэрлэснийг тус тус Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт системд бүртгэн, тайлагнав.
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга, постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хаяг	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга, постерийг улиралд 2-оос доошгүй удаа гарган, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хаяг болон харьяа	Улирал бүр	Нийгмийн даатгалын ерөнхий газрын ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан заримыг үндэслэн “Төрийн албан хаагчид бид” постер, ийг хийж Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 30 салбар нэгжийн цахим сайтаар дамжуулан ёс зүйтэй төрийн албан хаагч байхаа иргэд, даатгуулагчдад илэрхийлээд байна.

	болон харьяа Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн түгээх	Нийгмийн даатгалын газруудад хүргүүлж түгээсэн байна.		
3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайлан, Дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайланг Ёс зүйн хорооны баталсан маягтын дагуу улирал бүр, Дэд хорооны үйл ажиллагааны тайланг дараа оны нэгдүгээр улиралд батгаан Ёс зүйн хороонд хүргүүлсэн байна.	Улирал бүр	Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-нд 2025 онд нийт 9 гомдол, мэдээллийг иргэд, төрийн албан хаагчдаас ирүүлсэн ба үүнээс 3 гомдлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны харьяалан шийдвэрлэх гомдол биш байх тул харьяаллын дагуу буюу Орхон, Дархан-Уул, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороодод шилжүүлсэн. Харин 4 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хороо гомдлыг хүлээн авч, төрийн албан хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг шаардлага, хориглолтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргасан. Ёс зүйн дэд хорооноос ёс нийт 4 дүгнэлт гарсан бөгөөд, ёс зүйн зөрчилгүй гаргаагүй тухай 2 дүгнэлт, Ёс зүйн зөрчилтэй тухай 2 дүгнэлтийг тус тус гаргасан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу ёс зүйн зөрчил гаргасан тухай 2 дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтан, Ёс зүйн хороонд тус тус хүргүүлсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайланг Ёс зүйн хороонд улирал бүр хүргүүлэн ажиллав.
4	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргэх	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргүүлсэн тоо байна.	Тухай бүр	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргэх арга хэмжээний хүрээнд дараах зөвлөмж чиглэлийг хүргүүлээд байна. Үүнд: Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөж, төрийн албан хаагчийн ёс зүйг сахих, зан харилцаа, хандлагаараа хамт олноо үлгэрлэн, иргэдэд хүндэтгэлтэй хандаж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэж ажиллах, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдээс иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь,

				хугацаа тогтоох, цуцлах үйл ажиллагааг явуулахдаа иргэдтэй зохисгүй харьцах, зан харьцааны зөрчил гаргах, маргалдах асуудал цаашид ч гарах магадлалтай тул хурлын танхимд камер байршуулж хурлын явцад хяналт тавих, камерийн бичлэгийг тодорхой хугацаанд хадгалж, архивлах боломжийг бүрдүүлэх талаар салбар зөвлөлүүддээ албан ёсоор чиглэл өгч ажиллахыг Ёс зүйн дэд хорооны даргын 04/1103, 04/1102 албан бичгүүдээр; - Архангай аймгийн Нийгмийн даатгалын газарт Ёс зүйн дэд хороог байгуулахдаа 6 гишүүнтэйгээр жил бүр шинэчлэн баталж байгаа нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам зөрчсөн байх тул Ёс зүйн дэд хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дахин байгуулах, дахин байгуулахдаа нийт албан хаагч нар бүгд нэр дэвшигч байх, санал хураалтад оролцуулан байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 04/2845 дугаар албан бичгээр; - Нийгмийн даатгалын салбарын нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, томилох эрх бүхий албан тушаалтнуудтай 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж Нийгмийн даатгалын салбарт гарч байгаа ёс зүйн зөрчил, Ёс зүйн дэд хороодын нийтлэг гаргаж байгаа алдаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх, дотоод зохион байгуулалт хийж ажиллах талаар чиглэл өгөв.
5.	Нийгмийн даатгалын нийт албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх сургалт, Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд “Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг удирдан	Нийт албан хаагчид, салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.	II, III улиралд	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав. Уг хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт нийт 7 удаагийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 380, цахимаар 950 гаруй албан хаагчийг хамруулав.mНийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн

	зохион байгуулах” мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах			албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав.
6	“Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлуулах	“Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн байна.	IV улиралд	“Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”- ийг 2018 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар хүчингүй болгосон бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотой Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагч нарын буюу “Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлахаар дүрмийн төсөл боловсруулан санал авахаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн дарга нарт тус тус хүргүүлээд байна.
7	Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан албан хаагчийн ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудын ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулан танилцуулах.	II улиралд	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудын ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулан танилцуулах арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдаас Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн шийдвэр гаргалтын төвшин дэх ёс зүйн төвшинг тогтоох судалгааг google forms ашиглан авсан. Судалгаанд нийт 960 албан хаагч хамрагдсан бөгөөд Нийгмийн албан хаагчийн шийдвэр гаргалтын ёс зүйн төвшин 70 хувь нь 35 оноогоор үнэдэгдэж эрсдэл бага үнэлэлдсэн, 10 хувь нь эрсдэл өндөр, 20 хувь нь эрсдэл дунд зэрэг гэж үнэлэгдсэн байна.
8	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох баримт бичгийг архивын асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгөх, харьяа Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороонд арга зүйн зөвлөгөө хүргэх	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох баримт бичгээр архивын хадгаламжийн нэгж бүрдүүлсэн байна.	IV улиралд	Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-нд 2025 онд нийт 9 гомдол, мэдээллийг иргэд, төрийн албан хаагчдаас ирүүлсэн ба үүнээс 3 гомдлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны харьяалан шийдвэрлэх гомдол биш байх тул харьяаллын дагуу буюу Орхон, Дархан-Уул, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороодод шилжүүлсэн. Харин 4 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хороо гомдлыг хүлээн авч, төрийн албан хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг шаардлага, хorigлолтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргасан.

				Дээрх ирүүлсэн гомдол, мэдээлэл, албан бичиг, дүгнэлт, хуралдааны тэмдэглэлийг цахим болон цаасан архивын нэгж бүрдүүлэн бэлтгэсэн. Архивын ажилтанд 2026 оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.
10	Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтнуудад Ёс зүйтэй ажиллах, манлайлах, хуульд заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр сургалт зохион байгуулах.	III улиралд	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдах 37 ажилтанд сургалтыг зохион байгуулж танхимаар 16, цахимаар 21 албан хаагчийг тус тус хамруулав.

-о0о-

Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар
сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

**Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний
шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт**

Аймаг, хот: Улаанбаатар хот

Байгууллагын нэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

№	Үзүүлэлт			Тоон мэдээлэл			
1.	Хүлээн авсан гомдол, мэдээллийн нийт тоо:			4			
	Үүнээс:	Гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр	Бичгээр	4			
			Цахим шуудангаар				
			Амаар				
			1111 төвийн харилцах утсаар				
			Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ				
			Дотоодын хяналт шалгалтаар				
	Гомдол, мэдээллийг зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлсэн үндэслэл	Гэмт хэргийн шинжтэй					
		Сахилгын шинжтэй	1				
Зөрчлийн шинжтэй							
Бусад							
2.	Гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагчийн нийт тоо:						
	Үүнээс:	Хүйс	Эр	1			
			Эм	3			
		Албан тушаал	Төрийн улс төрийн				
			Төрийн захиргааны	4			
			Төрийн тусгай				
			Төрийн үйлчилгээний				
			Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан				
			Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал				
			Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан				
			Авлигын эсрэг хуулийн 4.1.9-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн				
			Төрийн албан хаагчийн тухай хуульд заасан Албан тушаалын төрөл	Удирдах	4		
				Гүйцэтгэх			
				Туслах			
			3.	Ёс зүйн зөрчилд холбогдуулан шалгасан гомдол, мэдээллийн нийт тоо:			4
				Ёс зүйн зөрчлийн ангилал	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1, 8.2-т заасан зөрчлийн ангиллаар		8.1.1 - 1 8.1.3 - 2 8.2.8 - 1
			4.	Судлагдаж байгаа /шийдвэрлээгүй/ гомдол, мэдээлэл:			1

5.	Шийдвэрлэсэн ёс зүйн зөрчлийн нийт тоо:		4	
	Үүнээс:	Ёс зүйн зөрчил гаргаагүй:	2	
		Ёс зүйн зөрчил гаргасан:	2	
6.	Ёс зүйн хариуцлага ногдуулсан, хүлээсэн тоо:		1	
	Үүнээс:	Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ёс зүйн хариуцлага ногдуулсан	Гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйхыг үүрэг болгох	
			Олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох	
			Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах	
			Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах	
			Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах	1
	Сайн дураар ёс зүйн хариуцлага хүлээсэн	Хамт олноос уучлалт гуйх	Гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйх	
			Олон нийтийн өмнө уучлалт гуйх	
			Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх	
	7.	Харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороонд гаргасан гомдлын тоо:		1
Үүнээс:		Судлагдаж байгаа /шийдвэрлээгүй/ гомдол, мэдээлэл:		
		Дүгнэлтийг хэвээр үлдээсэн:		1
		Дүгнэлтийг хүчингүй болгосон:		
8.	Шүүхэд гаргасан гомдлын тоо:		1	
	Үүнээс:	Шийдвэрийг хэвээр үлдээсэн:	-	
		Шийдвэрийг хүчингүй болгосон:	-	

Тайлан гаргасан:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/ М.Гэрэлмаа /

Тайланг хянасан:
Ёс зүйн дэд хорооны дарга

/ Ц.Ганцэцэг /

